



МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН
ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

ГИШҮҮН ХОРШООДЫН ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН
ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО





АГУУЛГА

	1. Сүү, сүүн бүтээгдэхүүн5
	2. Мах, махан бүтээгдэхүүн17
	3. Хүнсний ногоо, хатаасан ногоо 23
	4. Арвай буудай29
	5. Жимс, жимсгэнэ 32
	6. Даршилсан ногоо 35
	7. Зөгийн бал 39
	8. Хувцас эдлэл 43
	9. Бусад51



ӨМНӨХ ҮГ



Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо 21 аймаг, нийслэлд салбартай, 851 хөдөө аж ахуйн хоршооны 200 мянга гаруй малчид, тариаланчдыг эгнээндээ нэгтгэн тэдний дуу хоолой болж улс орон даяар хоршооллын хөдөлгөөнийг өрнүүлж ажилгүйдэл ядуурлыг бууруулах, гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ХАА-н хоршоологчдын нэгдсэн төв байгууллага юм.

Үндэсний холбооны гишүүн хоршоодын 56,1% нь мал аж ахуй, 28,9% нь газар тариалан, 9,4% нь худалдаа, үйлчилгээ, 6,6% нь жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж орон нутагтаа болон төрийн захиргааны байгууллагуудад гэрээний дагуу нийлүүлж ажиллаж байна.

Үндэсний холбоо нь гишүүддээ үзүүлэх үйлчилгээ болон 2022-2030 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний дагуу хөдөө аж ахуйн хоршоодын түүхий эд бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх орчин нөхцлийг сайжруулах, хоршоодын үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд Хөдөө аж ахуйн хоршоодын шилдэг бүтээгдэхүүний танилцуулгыг хэвлүүллээ.

Тус танилцуулгад 15 аймаг, нийслэлийн 27 сумын 33 хоршооны үйлдвэрлэсэн 41 багц бүхий шилдэг 131 нэр төрлийн бүтээгдэхүүнийг багтаан Та бүхэнд толилуулж байна.



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Сүү, сүүн бүтээгдэхүүн нь кальци, уураг, витамин D зэрэг олон төрлийн амин дэм, эрдэс бодисоор баялаг тул яс, шүдийг бэхжүүлж, булчингийн нөхөн сэргэлтэнд тусалж, хоол боловсруулах системийг дэмжихээс гадна, энергийн эх үүсвэр болж, биеийн ерөнхий эрүүл мэндийг сайжруулахад чухал үүрэгтэй тэжээллэг бүтээгдэхүүн юм. Сүүний тосыг уламжлалт болон үйлдвэрийн аргаар боловсруулан авсан хүнс нь тослог цагаан идээ ба тослог нь 10%-иас дээш байна. Тослог цагаан идээнд өрөм, зөөхий, цөцгий, шар тос, цагаан тос, айргийн тос орно.

ААРУУЛ

Сүүг исгэж, шүүж, хатаан гаргаж авдаг, уураг, кальциар баялаг уламжлалт сүүн бүтээгдэхүүн юм.

Ааруул нь кальциар баялаг, удаан хугацаанд хадгалагддаг сүүн бүтээгдэхүүн бөгөөд шингэц сайтай, хоол боловсруулах үйл явцыг дэмжих, зөөвөрлөхөд хялбар, байгалийн гаралтай тэжээллэг хүнс юм.

ӨРӨМ

Малын сүүн бүтээгдэхүүн. Хөөрүүлсэн сүүний дээгүүр тогтсон цөцгийрсөн идээг өрөм гэнэ. Өрөм хийх явцыг өрөм тогтоох, загсаах гэнэ. Гол төлөв үхэр, сарлагийн сүүгээр өрөм хийнэ.

ЗӨӨХИЙ

Зөөхий нь хөөрүүлсэн сүүг царцааж гарган авдаг, өтгөн бүтэцтэй, шим тэжээлээр баялаг сүүн бүтээгдэхүүн юм. Зөөхий 15–25 %-ийн тослогтой бөгөөд илчлэг чанар өндөртэй бүтээгдэхүүн учир хүний биед амархан шингэдэг. Мөн цус багадах, хоол боловсруулах эрхтний өвчлөл болон хоолны дуршил буурсан үед хэрэглэхэд нэн тохиромжтой.

ЦӨЦГИЙ

Цөцгий нь сүүг хөөрүүлж, тослогийг нь ялган гаргаж авдаг өтгөн бүтэцтэй, өөх тос болон амин дэмээр баялаг сүүн бүтээгдэхүүн юм. Цөцгий 20–33%-ийн тослогтой байдаг. A,D,E витамин, кальциар баялаг, тослогийн өндөр агууламжтай тул амт, идээшилтийг нэмэгдүүлж, салат, шөл, амттан зэрэг олон төрлийн хоолонд амт оруулахад өргөн ашигладаг бөгөөд химийн нэмэлт бодисгүй тул эрүүл мэндэд хоргүй сүүн бүтээгдэхүүн юм.

ЭЭЗГИЙ

Сүүг буцалгаж, халаасны дараа гарган авдаг хатуу, уураг, кальциар баялаг уламжлалт сүүн бүтээгдэхүүн юм. Ээзгий нь уураг, өөх тос, кальциар баялаг, хадгалахад хялбар, эрүүл мэндэд тустай уламжлалт сүүн бүтээгдэхүүн юм. Эрүүл мэндэд тустай, амттай, зөөвөрлөхөд хялбар, хоол боловсруулахад сайн, мөн эрүүл зууш болон олон төрлийн хоолонд нэмэлт амт оруулахад тохиромжтой юм.

ШАР ТОС

Сүү эсвэл өрмөөс тосыг нь ялгаж, халааж боловсруулан гаргаж авдаг, шим тэжээлээр баялаг сүүн бүтээгдэхүүн юм. Шар тос нь тослог өндөртэй, витамин A, D, E-ээр баялаг бөгөөд амт, үнэр сайтай, биеийн энергийг нэмэгдүүлж, дархлааг дэмжих, хоолонд амт оруулахад өргөн хэрэглэгддэг, удаан хугацаанд хадгалахад тохиромжтой бүтээгдэхүүн юм.

ШИМИЙН АРХИ

Сүү, цагаан идээнээс гаргаж авдаг нэгэн өвөрмөц бүтээгдэхүүн бол шимийн архи юм. Улс орон болгон өөрийн уламжлалт аргаар архи үйлдвэрлэдэг. Гэхдээ манайх шиг цагаан идээнээс гаргаж авсан нь байхгүй болов уу. Шимийн архийг үнээний, ингэний болон ямааны сүүний аарцаар хийнэ. Шимийн архи нь эрүүл мэндэд тустай, уламжлалт хүнсний онцгой бүтээгдэхүүн юм.



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠦᠨ



Аймаг: Архангай
 Сум: Өндөр-Улаан
 Хоршооны нэр: **АР БАНЧ**
 Бүтээгдэхүүний нэр: **ТАВГИЙН ИДЭЭНИЙ БАГЦ**
 /өрөм, ээзгий, ааруул, хорхой ааруул, шар тос, ээзгийтэй тос, хайлмаг/
 Хэмжээ: 25 ширхэг, 1кг, 500гр
 Орц: Сарлагийн сүү



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



ᠰᠦᠭᠡᠨᠠᠷᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ

Аймаг: Сүхбаатар
Сум: Баруун-Урт
Хоршооны нэр: **УЛАМ ЭХЭН**
Бүтээгдэхүүний нэр: **ДУГУЙ ААРУУЛ, ЧИПСЭН ААРУУЛ, ХОРХОЙ ААРУУЛ, ШАР ТОС, НЭРМЭЛ**
Хэмжээ: 1л, 500гр
Орц: Үнээний сүү



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠲᠡᠬᠡᠭᠡᠨ



Аймаг:	Сэлэнгэ
Сум:	Цагааннуур
Хоршооны нэр:	ХУУРЧ СҮРЭГ
Бүтээгдэхүүний нэр:	ЦӨЦГИЙ, ААРУУЛ
Хэмжээ:	300гр, 500гр
Орц:	Үнээний сүү



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



ᠬᠥᠪᠰᠦᠭᠡᠯ
ᠡᠭᠡᠰᠡᠭᠡᠢ

Аймаг:	Хөвсгөл
Сум:	Тосонцэнгэл
Хоршооны нэр:	СҮҮН ДАЛАЙ
Бүтээгдэхүүний нэр:	ЭЭЗГИЙ
Орц:	Үнээний сүү, ямааны сүү
Хэмжээ:	500гр



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠲᠡᠬᠡᠭᠦᠨ



Аймаг:	Завхан
Сум:	Идэр
Хоршооны нэр:	ЦАГААН АЛТ ШИНЭ ЭХЛЭЛ
Бүтээгдэхүүний нэр:	САРЛАГ БАГЦ /сарлагийн ааруул, эээгий, шар тос, шимийн архи/
Орц:	Сарлагийн сүү
Хэмжээ:	300гр, 150гр, 500гр



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



ᠬᠣᠷᠬᠣᠢ ᠠᠠᠷᠠᠭᠤᠯ
ᠠᠠᠷᠠᠭᠤᠯ
ᠡᠭᠡᠵᠢᠭᠢ

Аймаг: Говьсүмбэр
Сум: Сүмбэр
Хоршооны нэр: **ИРМҮҮН БИЛҮҮТ ХОШУУ**
Бүтээгдэхүүний нэр: **ААРУУЛ, ЭЭЗГИЙ, ХОРХОЙ ААРУУЛ**
Орц: Аарц, ааруул, ээдэм
Хэмжээ: 500гр



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠲᠡᠬᠡᠭᠦᠨ



Хот: Улаанбаатар
 Дүүрэг: Сонгинохайрхан
 Хоршооны нэр: **"ЖАРГАЛАНТ МИЛК" ДУНДЫН ХОРШОО**
 Бүтээгдэхүүний нэр: **АЛАГАА БРЭНД**
 /хорхой ааруул, шар тос, зөөхий, сүү/
 Орц: Үнээний сүү
 Хэмжээ: 200гр, 120гр, 230гр, 1л



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



ᠰᠤᠢᠨᠪᠦᠳᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠦᠨ

Аймаг: Архангай
Сум: Эрдэнэбулган
Хоршооны нэр: **ОД-КР**
Бүтээгдэхүүний нэр: **САРЛАГИЙН ШАР ТОС**
Орц: Сарлагийн өрөм
Хэмжээ: 200гр



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠲᠡᠬᠡᠭᠡᠨ



Аймаг:	Увс
Сум:	Өндөрхангай
Хоршооны нэр:	ШИНЭ ЗАМ УВС
Бүтээгдэхүүний нэр:	ЦЭВЭР ШАР ТОС
Орц:	Үхрийн сүү
Хэмжээ:	100гр



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН



ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠦᠨ

Аймаг: Говьсүмбэр
Сум: Сүмбэр
Хоршооны нэр: **ЭХЭН СҮВЭЙН БАЯЛАГ**
Бүтээгдэхүүний нэр: **ЦАГААН ИДЭЭНИЙ БАГЦ**
/авдар, сүү, ааруул, хайлмаг, амтат аарц, ингэний хоормог/
Орц: Үнээний сүү, ингэний сүү
Хэмжээ: 500гр, 100мл, 500мл



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

ᠰᠦᠭᠦᠨᠪᠦᠳᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠡᠨ



Аймаг:	Дорнод
Сум:	Цагаан-Овоо
Хоршооны нэр:	ЭЛСТ ЦАГААН ТЭМЭЭТ
Бүтээгдэхүүний нэр:	ШИМИЙН АРХИ
Орц:	Үнээний сүүний аарц
Хэмжээ:	500мл



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

Мах, махан бүтээгдэхүүн нь уураг, төмөр, цинк, В витаминаар баялаг бөгөөд хүний биеийн булчингийн хөгжил, ясны бэхжилт, энергийн хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй B12 витамин болон төмрийн өндөр агууламжтай. Цусны улаан эсийн нийлэгжилтийг дэмжиж, цус багадалтаас сэргийлдэг тул эрүүл мэндэд нэн тустай, мэдрэлийн системийн үйл ажиллагааг дэмжиж, бодисын солилцоог сайжруулахад тусалдаг.

ҮХРИЙН БОРЦ

Борц нь уриншуулж хатаасан мах бөгөөд олон зуун жил уламжлан ирсэн монгол үндэстний өвөрмөц хүнс юм. Муудаж ялзрахгүй, чанараа алдахгүй, шим шүүсээ дотроо агуулж байдаг, хичнээн ч удаан хадгалж болдогоороо онцлогтой уураг, төмрөөр баялаг уламжлалт бүтээгдэхүүн юм.

САРЛАГИЙН БОРЦ


Сарлагийн мах нь холестерин багатай, бүдүүвтэр ширхэгтэй, цайр, зэс, төмөр ихээр агуулагддаг шим тэжээл өндөр бүтээгдэхүүн юм.

САМГЁБСАЛЬНЫ МАХ

Гахайн мах нь уураглаг бөгөөд нүүрс ус багатай, витамин, эрдэс, амин хүчил агуулдаг. Омега өөх тос, эрдэс бодис, В бүлгийн амин дэмийн өндөр агууламжтай тул гахайн мах нь булчин, тархи, мэдрэлийн системд сайн нөлөө үзүүлдэг.

ХАТААСАН ТАВАН ЦУЛ

Дайвар бүтээгдэхүүн нь 15–16%-ийн уурагтай, эрдэс, шим тэжээлээр баялаг хүнс юм.



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН


БҮТЭЭГДЭХҮҮН



Аймаг:	Говь-Алтай
Сум:	Бигэр
Хоршооны нэр:	АЛТАН ТЭВШ
Бүтээгдэхүүний нэр:	БОРЦ
Орц:	Монгол үхрийн мах
Хэмжээ:	300гр



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН



Хангайн идээ



Аймаг: Архангай
Сум: Хангай
Хоршооны нэр: **ХАНГАЙН ИДЭЭ**
Бүтээгдэхүүний нэр: **САРЛАГИЙН БОРЦ**
Орц: Сарлагийн мах
Хэмжээ: 500гр, 300гр



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН


ᠮᠠᠬᠤ, ᠮᠠᠬᠠᠨ ᠪᠦᠳᠡᠭᠳᠡᠬᠡᠭᠡᠨ



Аймаг:	Өвөрхангай
Сум:	Арвайхээр
Хоршооны нэр:	ТҮМНИЙ БУЯН ДАЛАЙ
Бүтээгдэхүүний нэр:	ТАВАН ШИМТ БРЭНД
Орц:	Хонины таван цул
Хэмжээ:	120гр, 200гр



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН



ᠰᠠᠮᠭᠡᠪᠰᠠᠯ

Аймаг: Говьсүмбэр
Сум: Сүмбэр
Хоршооны нэр: **ЭХЭН СҮВЭЙН БАЯЛАГ**
Бүтээгдэхүүний нэр: **САМГЁБСАЛЬ**
Орц: Гахайн мах
Хэмжээ: 500гр



МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

ХҮЧ ТАМИРЫН ШӨЛ



Аймаг:	Хөвсгөл
Сум:	Мөрөн
Хоршооны нэр:	ДЭЛГЭРЭХ ШИМТ ХӨРС
Бүтээгдэхүүний нэр:	ХҮЧ ТАМИРЫН ШӨЛ
Орц:	Хонины таван цул, халуун чинжүү, сармис, давс, гоньд, хар перец, оливын тос, сонгино
Хэмжээ:	100гр



ХҮНСНИЙ НОГОО, ХАТААСАН НОГОО

Хүнсний ногоо нь хүний биеийн эрүүл мэндэд онцгой ач тустай, олон төрлийн шим тэжээл агуулсан байдаг. Ногоо нь эслэг, аминдэм, эрдэс бодис, антиоксидант болон усны эх үүсвэр болж, бие махбодийг өвчин эмгэгээс хамгаалах, эрүүл мэндийг дэмжих чухал үүрэгтэй. Ногоо тус бүр нь өвөрмөц найрлагатай тул тэдгээрийн тус бүрийн ач тусыг ойлгож хэрэглэх нь чухал юм.

БРОККОЛИ

Брокколи нь К, С аминдэм, кальци, төмөр зэрэг олон шим тэжээл агуулдаг. К аминдэм нь цусны бүлэгнэлд, кальци нь ясны эрүүл мэндэд нэн шаардлагатай. Мөн антиоксидантаар баялаг тул дархлааг сайжруулж эсийн гэмтлээс сэргийлнэ. Брокколи нь хорт хавдрын эсрэг үйлчилгээтэй сульфорафан агуулдаг бөгөөд хүний биеийн эсийн хамгаалалтын системийг сайжруулж, үрэвслийг бууруулна.

ӨРГӨСТ ХЭМХ

Өргөст хэмх нь уснаас бүрддэг (90 гаруй хувь) тул шингэн нөхөхөд маш сайн. Уснаас гадна кали, магни, С аминдэмээр баялаг тул шингэний тэнцвэрийг хадгалах, дархлааг сайжруулахад тустай. Биеийн шингэнийг нөхөж, цусны даралтыг тогтворжуулна. Мөн арьсны чийгшлийг сайжруулж, арьсны эрүүл мэндийг дэмжинэ.

УЛААН ЛООЛЬ

Улаан лооль нь ликопин хэмээх антиоксидант бодис агуулдаг. Ликопин нь зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эсийн гэмтлээс хамгаалах үйлчилгээтэй. Түүнчлэн С аминдэм, калиар баялаг тул дархлаа болон зүрхний эрүүл мэндийг сайжруулна. Ликопин нь хорт хавдрын эсрэг үйлчилгээтэй тул энэ ногоог тогтмол хэрэглэх нь уушги, арьс, ходоодны хорт хавдраас урьдчилан сэргийлнэ. Мөн арьсны хөгшрөлтийг удаашруулж, зүрхний үйл ажиллагааг дэмждэг.

БУУЦАЙ

Бууцай нь төмөр, кальци, калиар баялаг бөгөөд антиоксидантуудыг агуулдаг. Эдгээр шим тэжээл нь цусны эргэлт, ясны эрүүл мэнд, дархлааг дэмжихэд тустай. Бууцай нь цус багадалтаас урьдчилан сэргийлж, ясны эрүүл мэндийг дэмждэг. Мөн төмөр нь хүчилтөрөгчийн тээвэрлэлтийг сайжруулж, биеийн эрч хүчийг нэмэгдүүлнэ.

ЭРДЭНЭ ШИШ

Эрдэнэ шиш нь В бүлгийн витаминууд болох В1, В2, РР, В5, В6, В9, кали, фосфор, магни, натри, кальци, төмөр, цайр, зэс, селен гэх мэт эрдэс бодисоор баялаг юм. Эрдэнэ шишийг тогтмол хэрэглэх нь зүрхний өвчин, чихрийн шижин, хорт хавдрын эрсдэлийг бууруулдаг байна.

ХУЛУУ

Хулуу нь өндөр гликемик индекстэй хүнсэнд тооцогддог. Цусан дах сахарын хэмжээ огцом нэмэгдэхэд нөлөөлдөг учраас чихрийн шижинтэй хүмүүс хэрэглэхийг хориглох заалттай байдаг.

ХАШ

Хаш нь хүний эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлдэг нь түүний баялаг найрлагатай холбоотой юм. Тиймээс уусдаг элсэн чихэр, эслэг, уураг, кали, уусдаг сахар, пектин, кальци, натри, фосфор, магни, төмөр, В1, В2, В5, С, РР витамин агуулдаг.

ХАЛУУН ЧИНЖҮҮ

Халуун чинжүү нь бусад хүнсний ногоо болон чинжүүнээс ялгарах гол онцлог нь ам дарвигнуулсан халуун амт юм. Уг халуун амтыг үүсгэдэг Капсаицин хэмээх бодис нь хүний биед маш их ашиг тустай байдаг.

ХҮРЭН МАНЖИН

Хүрэн манжин анагаах увидастай учраас байгалийн гаралтай эм ч гэж нэрлэх нь бий. Ялангуяа амин дэм дотроо С витамин болон В6, фолийн хүчил, магни, бетайн, калийн агуулах хэмжээ хамгийн өндөр, антиоксидантаар баялаг төдийгүй үрэвслийн эсрэг, хоргүйжүүлэх үйлчилгээтэй хүнсний ногоо юм.



ХҮНСНИЙ НОГОО, ХАТААСАН НОГОО

Хүнсний ногоо



Аймаг:

Сэлэнгэ

Сум:

Сант

Хоршооны нэр:

"СЭЛЭНГЭ ТАВАН ХАЙРХАН" ДУНДЫН ХОРШОО

Бүтээгдэхүүний нэр: ХҮНСНИЙ НОГОО

/хулуу, улаан лооль, хаш, брокколи, салат навч, өргөст хэмх чинжүү/



ХҮНСНИЙ НОГОО, ХАТААСАН НОГОО



Аймаг:

Сэлэнгэ

Сум:

Шаамар

Хоршооны нэр:

СЭЛЭНГИЙН БЭЛЧИР

Бүтээгдэхүүний нэр: **ХҮНСНИЙ НОГОО**

/хулуу, чинжүү, халуун чинжүү, эрдэнэ шиш, улаан лооль, хаш/

Хүнсний ногоо, хатаасан ногоо



ХҮНСНИЙ НОГОО, ХАТААСАН НОГОО

Хүнсний ногоо, хатаасан ногоо



Аймаг:	Өмнөговь
Сум:	Даланзадгад
Хоршооны нэр:	ХАЯА ГОЛ
Бүтээгдэхүүний нэр:	ХАТААСАН НОГОО /хаш, хүрэн манжин, хулуу, холимог ногоо/
Орц:	Хүнсний ногоо
Хэмжээ:	100гр, 80гр, 50гр



ХҮНСНИЙ НОГОО, ХАТААСАН НОГОО



Аймаг:	Сэлэнгэ
Сум:	Шаамар
Хоршооны нэр:	ОРГАНИК БАЛ
Бүтээгдэхүүний нэр:	ЗӨГИЙН БАЛТАЙ ХАТААСАН ХҮРЭН МАНЖИН
Орц:	Зөгийн бал, хүрэн манжин
Хэмжээ:	100гр

Зөгийн балтай хатаасан хүрэн манжин



ХҮНСНИЙ НОГОО, ХАТААСАН НОГОО

Хүнсний ногоо, хатаасан ногоо



Аймаг:	Сэлэнгэ
Сум:	Мандал
Хоршооны нэр:	ШИРХЭНЦЭГ ӨГӨӨЖ
Бүтээгдэхүүний нэр:	ХООЛ АМТЛАГЧ
	/халуун чинжүү, хатаасан базилик, цоохор майлз/
Орц:	Халуун чинжүү, базилик, майлз
Хэмжээ:	80гр



АРВАЙ БУУДАЙ

Хүн төрөлхтний хоол хүнсний чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг нь арвай буудай юм. Хүнсний бүтээгдэхүүн дундаа арвай буудай нь амин дэмийн хамгийн чухал эх үүсвэр бөгөөд бусад дагалдах хүнсэнд мах, сүү, жимс, ногоо ордог гэж үздэг. Тогтмол хэрэглээ нь чихрийн шижин, зүрх судасны өвчин, таргалалт, цусны даралт ихсэх зэрэг өвчний эрсдлийг бууруулдаг. Арвай буудай нь 6-12%-ийн уураг агуулах бөгөөд үүнд альбумин, глобулин, глютин (проламин, глиадин, глютелин) зэрэг уургаас тогтоно.

АРВАЙН ГУРИЛ

Монголчуудын уламжлалт хоол хүнсний нэг төрөл бол тарианы гурил буюу "арвайн гурил, болсон гурил" юм. Арвайн гурил нь ядаргаа тайлахаас гадна амин дэм, уураг, нүүрс ус болон эслэг их агуулдаг ба гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг идэвхжүүлэх сайн талтай. Өтгөн хатах үед эмийн журмаар хэрэглэх нь элбэг. Мөн цөсний хүүдийн ханыг цочроож цөс ялгаруулалтыг нэмэгдүүлэх ба судас хатуурахаас сэргийлнэ.

СУЛИЙН ГУРИЛ

Суль нь Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Дорнод Говь, Олон нуурын хөндий, Говь-Алтай, Дундговь зэрэг аймгийн нутгаар 170 см хүртэл өндөр ургадаг ургамал юм. Сулийн гурил нь тэжээллэг чанар сайтай учир хөхүүл эхэд сүү оруулах, нойргүйдэл, мэдрэлийн ядаргаа зэрэгт тамир тэтгэж илааршуулах увдистай ба ядаргаа тайлах, хаван буулгах, суулгалтыг зогсоох, цус төлжүүлэх үйлчилгээтэй.

ЦУЛЬХИРИЙН ГУРИЛ

Цульхир нь элсэрхэг хөрсөнд ургадаг зэрлэг амууны төрлийн хүнсний ургамал юм. Чихрийн шижин, цөс хөөх, ядарч сульдах, элэгний өөхөн нэвчилт сааруулах болон түрүү булчирхай, цистит өвчнийг илааршуулахад тустай.

БОГ БУДАА

Бог будаа нь уураг, нүүрс усны агууламж өндөртэй, фосфор, кали, магни, B1, B2, PP зэрэг амин дэмээр баялаг, илчлэг өндөртэй, шингэц сайтай, ясны сийрэгжилт, цус багадах, өтгөн хатахаас урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй хүний эрүүл мэндэд онцгой ач холбогдолтой бүтээгдэхүүн юм.



АРВАЙ БУУДАЙ

Улаанбаатар



Аймаг:	Говь-Алтай
Сум:	Хөхморьт
Хоршооны нэр:	СУЛЭН ДЭНЖ
Бүтээгдэхүүний нэр:	СУЛИЙН ГУРИЛ, ЦУЛЬХИРЫН ГУРИЛ
Орц:	Сул, цульхир
Хэмжээ:	500гр, 200гр



АРВАЙ БУУДАЙ



МОНГОЛЫН
АЖ АХУЙН
ХОРШООЛОГЧДЫН
ҮНДЭСНИЙ
ХОЛБОО

Аймаг: Булган
Сум: Хангал
Хоршооны нэр: **СҮМИЙН НУГА**
Бүтээгдэхүүний нэр: **АРВАЙ БУУДАЙН БАГЦ**
/бог будааны чангаамал, үсэлсэн арвай, цайны дээж/
Орц: Халтар арвай, бог будаа, овъёос, арвай
Хэмжээ: 1кг, 500гр, 300гр, 125гр

ЖИМС, ЖИМСГЭНЭ

Жимс нь мод, бут гэх мэт ургамлын шүүслэг үр бөгөөд хүний биед амархан шингэдэг, шим тэжээлт хүнсний бүтээгдэхүүн юм. Бүтцээр нь үрт жимс, яст жимс, жимсгэнэ гэж ангилна.

ЧАЦАРГАНА

Чацаргана нь исгэлэн амттай, бүлээн чанартай, хуурай, тослог жимс юм. Европ, Азид 6 зүйл, 12 дэд зүйлийн чацаргана зэрлэгээрээ ургадаг, өргөн тархсан ургамал юм. Чацарганы бут нь ихэнхдээ 0.5–6 м өндөртэй байх боловч хааяа Төв Азийн хуурай, элсэрхэг нутагт 10м хүртэл ургах нь бий. Чацаргана нь ханиадыг зогсоох, цусыг шингэрүүлэх, хүний биеийг эрүүлжүүлж, зүрх судасны системийн эргэлтийг сайжруулдаг.

Уг жимс нь маш бага хэмжээний нягтралтай уураг агуулдаг бөгөөд артерийн судасны хана гэмтэхээс хамгаална. Судсыг хамгаалж судасны хатуурал болон зүрхний өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Судлаачид 8ш чацаргана жимс нь биеийн тамирын үед гэмтсэн эд эсийг эдгээдэг чадалтай болохыг тогтоожээ. Мөн маш их хэмжээний уураг, хүчил, витамин, кальци, фосфор, магни, натри зэрэг хүний биед зайлшгүй шаардлагатай элементүүдийг агуулдаг. Ходоодыг эрүүлжүүлж, гэдсийг цэвэрлэн, уушгийг зөөллөж, цус төлжүүлж, өтгөн шингэнийг тохируулж, дэлүүг эрүүлжүүлэх зэрэг олон талын ач тустай.

ҮХРИЙН НҮД

Үхрийн нүд тошлойн овгийн ургамлын төрөл юм. Төрөл нь дотроо 150 гаруй зүйл байдаг. Үхрийн нүд нь 1–2м өндөр, бут хэлбэрийн сөөг ургамал 5–6 дугаар сард цэцэглэж 7–8 дугаар сард жимс нь боловсордог.

Гүйцэд боловсорсон үхрийн нүд хүрэн, хар хүрэн өнгөтэй, шүүслэг чихэрлэг, содон сайхан үнэртэй, амтлаг жимс бөгөөд А, В, С, Р витамин, чихэрлэг бодис, органик хүчил агуулна. Жимсийг гараар түүхэд хялбар, түүгээр чанамал, шүүс, ундаа чихрийн чөмөг, дарс хийхэд тохиромжтой. Үхрийн нүд жимсийг чийг бамын болон С амин дэмийн дутмагшил өвчний эмчилгээнд өргөн хэрэглэдэг.

ЧАЦАРГАНЫ ТОС

Чацаргана жимснээс ялгаж гаргасан тос нь А,Е,К,С,В бүлгийн амин дэмүүд, каротин зэрэг биологийн идэвхт нэгдлүүдээр баялаг бөгөөд эсийн исэлдэн ангижрах урвалд оролцож уураг болон А витаминь солилцоог сайжруулдаг. Арьсанд тэжээл өгөх, цацраг туяаны нөлөөг бууруулах, үрэвслийг анагаах, судас хатуурах, шарх эдгээх, хөгшрөлтийг удаашруулах зэрэг чухал үйлчилгээтэй учир дотуур ба гадуур аль ч хэлбэрээр хэрэглэхэд тохиромжтой.



ЖИМС, ЖИМСГЭНЭ



УРВАС

Аймаг: Увс
Сум: Улаангом
Хоршооны нэр: **УРАН ЗУРВАС**
Бүтээгдэхүүний нэр: **ЧАЦАРГАНЫ ТОС, ЧАЦАРГАНЫ БОЛОН ҮХРИЙН НҮДНИЙ ӨТГӨРҮҮЛСЭН ШҮҮС, ҮХРИЙН НҮДНИЙ ЧАНАМАЛ**
Орц: Чацаргана, үхрийн нүд, элсэн чихэр
Хэмжээ: 100гр, 0,5л, 500гр



ЖИМС, ЖИМСГЭНЭ

ТУНГАЛАГ УСТ ШУРАГ



Аймаг:	Ховд
Сум:	Эрдэнэбүрэн
Хоршооны нэр:	ТУНГАЛАГ УСТ ШУРАГ
Бүтээгдэхүүний нэр:	ЧАЦАРГАНЫ ТОС, ЧАЦАРГАНЫ ӨТГӨРҮҮЛСЭН ШҮҮС, ҮХРИЙН НҮДНИЙ ӨТГӨРҮҮЛСЭН ШҮҮС
Орц:	Чацаргана, үхрийн нүд, цэвэршүүлсэн ус
Хэмжээ:	100гр, 50гр, 500мл



ДАРШИЛСАН НОГОО

Даршилсан ногоо нь амин дэм, эрдэс бодисоор баялаг. С, К витамин, кали, төмөр зэрэг дархлаа сайжруулах, ясны эрүүл мэндийг дэмжих, цусны эргэлтийг сайжруулах зэрэг олон төрлийн ач тустайгаас гадна калори багатай, эслэг ихтэй учир хоол боловсруулах системийг дэмжиж, удаан хугацаанд цатгалан мэдрэмж төрүүлдэг. Энэ нь жингээ барих эсвэл бууруулахад тусалдаг.

ДАРШИЛСАН ӨРГӨСТ ХЭМХ

Даршилсан өргөст хэмхний ашиг тусыг дархлааг нэмэгдүүлэх хэрэгсэл болгон ашиглаж болно. Даршилсан өргөст хэмх нь ходоод, гэдсэнд үүсдэг өвчин үүсгэгч нянг устгах чадвартайгаас гадна өөх шаталтыг өдөөдөг, сахарын түвшинг зохицуулдаг.

ЛУУВАНГИЙН ЧАНАМАЛ

Лууванд А,В,С витамин, төмөр, кальци, бета каротин, кали агуулагддаг. Эдгээр нь хүний биед шууд шингэж, маш их энерги өгдөг. Мөн лууван ходоод гэдсэнд хуримтлагдсан хорт бодисыг гаргаж зайлуулахад элгэнд тусладаг учраас биеийн эрхтнүүдийн ерөнхий эрүүл мэндийг сайжруулдаг. Ингэснээр бодисын солилцоо сайжирч хүний арьсыг уян зөөлөн болгож, арьсны эмгэгүүдийг багасган арьсыг улам гэрэлтүүлдэг.

ГИШҮҮНИЙ ЧАНАМАЛ

Гишүүнэ нь хавдрын эсийн гол амьд байх нөхцөл болсон сахрыг идэж устгадаг нь тогтоогдсон байна. Кальци, кали, К амин дэмээр баялаг бөгөөд үрэвслийн болон нянгийн эсрэг гайхалтай нөлөө үзүүлдэг.

ХАЛУУН ЧИНЖҮҮ

Халуун чинжүүнд рибофлавлин, төмөр, ниацин, кали, магни, мангани, витамин Е, А, В, В6, К зэрэг амин дэмүүд багтдаг ба цусны даралтыг хэвийн байлгахад тусалдаг. Үүнээс гадна энэхүү байгалийн эмчилгээ нь LDL холестерол болон триглицеридын түвшинг тэнцвэржүүлэхэд тусалдаг бөгөөд энэ нь зүрх судасны тогтолцооны эрүүл мэндэд сайнаар нөлөөлдөг.



ДАРШИЛСАН НОГОО

ᠳᠠᠷᠰᠢᠯᠢᠰᠠᠨ ᠨᠣᠭᠣᠭ᠎ᠠ



Аймаг:	Хөвсгөл
Сум:	Мөрөн
Хоршооны нэр:	АР БЭЛ БУЛАГ
Бүтээгдэхүүний нэр:	ЧАЦАРГАНТАЙ ЛУУВАНГИЙН ЧАНАМАЛ, ХҮРЭН МАНЖИНГИЙН ЧАНАМАЛ, ЛУУВАНГИЙН ЧАНАМАЛ, АНЬСТАЙ ХҮРЭН МАНЖИНГИЙН ЧАНАМАЛ, ГИШҮҮНИЙ ЧАНАМАЛ
Орц:	Чацаргана, лууван, нимбэг, хүрэн манжин, аньс, гишүүнэ, элсэн чихэр
Хэмжээ:	600гр, 550гр



ДАРШИЛСАН НОГОО



Халуун Чинжүү

Аймаг:

Сэлэнгэ

Сум:

Шаамар

Хоршооны нэр:

СЭЛЭНГИЙН БЭЛЧИР

Бүтээгдэхүүний нэр:

ХАЛУУН ЧИНЖҮҮ

Орц:

Халуун чинжүү, сармис, давс, хар перец, цэвэршүүлсэн ус

Хэмжээ:

800гр



ДАРШИЛСАН НОГОО

Хүрэн манжин
Даршилсан сармис



Аймаг:

Сум:

Хоршооны нэр:

Бүтээгдэхүүний нэр:

Орц:

Хэмжээ:

Хөвсгөл

Мөрөн

ДЭЛГЭРЭХ ШИМТ ХӨРС

**ХАЛУУН ЧИНЖҮҮ, ХҮРЭН МАНЖИН, ДАРШИЛСАН САРМИС,
САРМИСНЫ ГОЛ, ДАРШИЛСАН ЦАГААН ЛУУВАН, АМТАТ АДЖИКО, ШАРСАН БАЙЦАА**

Халуун чинжүү, сармис, давс, цууны хүчил, гоньд, хар перец, хүрэн манжин, цуу, элсэн чихэр, цагаан лууван, улаан лооль, амтат чинжүү, оливын тос, алимны цуу, байцаа, сонгино, гучугару, цэвэршүүлсэн ус

800гр, 500гр, 300гр



ЗӨГИЙН БАЛ

Зөгий нь цэцгээс цуглуулсан балыг биедээ шилжүүлэн ферментжүүлж задлан үүрэндээ хадгалдаг. Зөгийн үүр нь 35°C температуртай байдаг бөгөөд ажилчин зөгийнүүд үүрэн доторх агаарыг үргэлж сольж цэвэршүүлдэг тул ус нь ууршиж, чихэрлэгийн хэмжээ 80%-д хүрнэ. Найрлагад нь глюкоз, фруктозоос гадна витамин, эрдэс, амин хүчлүүд агуулагддаг. Зөгийн бал нь антиоксидантаар баялаг, дархлааг дэмжих, энерги сэргээх, хоол боловсруулах системийг сайжруулах, ханиалгыг намдаах, арьс арчилгаа, шарх эдгээх, зүрх судасны эрүүл мэндийг дэмжих зэрэг олон талын ашиг тустай байгалийн бүтээгдэхүүн юм. Зөгийн бал нь цэцгийн төрлөөс хамаарч амт, өнгө, үнэр, найрлага нь дараах байдлаар ялгаатай байдаг.

ЛЯНХУА ЦЭЦГИЙН ЗӨГИЙН БАЛ

Бүдэг өнгөтэй, хурц үнэргүй.

ХАР ХУАЙС ЦЭЦГИЙН ЗӨГИЙН БАЛ

Бүдэг хүрэн өнгөтэй, амт үнэрийн хувьд лянхуа цэцгийнхтэй ойролцоо.

БЭРСҮҮТ ЖҮРЖ ЦЭЦГИЙН ЗӨГИЙН БАЛ

Бэрсүүт жүрж буюу мандаринд тоос хүртээхэд зөгийг ашиглах болсон ба энэ төрлийн балны үйлдвэрлэл нь өссөн. Нимбэгэрхүү үнэртэй.

ХОШООНГОР ЦЭЦГИЙН ЗӨГИЙН БАЛ

Дэлхийд хамгийн их хэмжээгээр үйлдвэрлэгддэг. Хурц чихэрлэг үнэртэй боловч амт сул.

САГАГ ЦЭЦГИЙН ЗӨГИЙН БАЛ

Төмөр ихээр агуулдаг тул хар хүрэн өнгөтэй, өвөрмөц үнэртэй ба цус багадалтад сайн.

ТУУЛАЙН БӨӨР ЦЭЦГИЙН ЗӨГИЙН БАЛ

Гашуувтар, исгэлэндүү амттай



ЗӨГИЙН БАЛ

БҮТЭЭГДЭХҮҮН



Аймаг: Сэлэнгэ
 Сум: Баянгол сум
 Хоршооны нэр: **ХАРААГИЙН БАЯН ҮРС**
 Бүтээгдэхүүний нэр: **ТОД ОРГАНИК ЗӨГИЙН БАЛ**
 Хэмжээ: 400гр



ЗӨГИЙН БАЛ



БҮС
ГҮН
БАГ

Аймаг: Сэлэнгэ
Сум: Сант
Хоршооны нэр: "СЭЛЭНГЭ ТАВАН ХАЙРХАН" ДУНДЫН ХОРШОО
Бүтээгдэхүүний нэр: **ЗӨӨЛӨН БРЭНД БАГЦ**
/зөгийн бал, шар тос, сүүлний тос/
АНХИЛ БРЭНД
/зөгийн бал/
Хэмжээ: 50гр, 450гр



ЗӨГИЙН БАЛ

БҮТЭЭГДЭХҮҮН



Аймаг:	Сэлэнгэ
Сум:	Шаамар
Хоршооны нэр:	ОРГАНИК БАЛ
Бүтээгдэхүүний нэр:	ЗӨГИЙН БАЛ
Хэмжээ:	600гр



ХУВЦАС ЭДЛЭЛ

Хувцас эдлэл нь нүүдэлчин ахуй амьдрал, уламжлал, түүх соёлтой салшгүй холбоотойгоор хөгжиж ирсэн. Хувцас нь байгаль орчин, цаг агаарын нөхцөл байдалд тохирсон, тав тух, дулааныг хангах үүрэгтэйгээс гадна, үндэстэн ястны ялгааг илэрхийлэх үүрэгтэй байдаг.

НООСОН ХӨНЖИЛ

Хонины ноосоор хийсэн хөнжил нь дулаан хадгалах өндөр чадвартай, биед эвтэйхэн бөгөөд байгалийн гаралтай тул харшил үүсгэдэггүй. Ноосон хөнжил нь хүйтэн сэрүүн нөхцөлд биеийн дулааныг хадгалж, биед дулаан мэдрэмж төрүүлдэг онцлогтой. Ноос нь чийгийг өөртөө шингээж, хөлрөх үед чийгийг биеэс зайлуулан гадаргуу руу гаргадаг тул хуурай, дулаан байдлыг хадгалдаг. Уян хатан бүтэцтэй бөгөөд хөнгөхөн, хүйтэнд хатуурдаггүй тул биед эвтэйхэн, байгаль орчинд ээлтэй, хурдан задардаг.

МОНГОЛ ГУТАЛ

Монгол гутал нь бөх бат, дулаан хадгалах чанартай. Гутлын хоншоор нь дээш өргөгдсөн хэлбэртэй байх бөгөөд энэ нь байгаль орчинтой зохицож амьдрах, газрын хөрсийг гэмтээхгүй байх философиос үүдэлтэй. Монгол гутал нь арьс, эсгий, нэхий зэрэг байгалийн материалаар хийгддэг. Өвлийн гутал нь дотортой байдаг бол зуны гутал нь нимгэн арьсаар хийгдсэн байдаг.

НООСОН ЭДЛЭЛ

Хонины ноосон эдлэл нь эрт дээр үеэс Монголчуудын амьдралд чухал байр суурь эзэлж ирсэн бөгөөд байгалийн гаралтай, дулаан хадгалах чадвар сайтай, эрүүл мэндэд ээлтэй материал юм. Хонины ноос нь монгол орны хатуу ширүүн уур амьсгалд зохицсон, бат бөх, дулаахан бөгөөд элэгдэлд тэсвэртэй байдгаараа онцлогтой.

ХАНТААЗ

Хантааз нь дээлийн гадуур өмсдөг богино, ханцуйгүй хувцас юм. Эмэгтэй хантааз нь илүү гоёмсог хээ, чимэглэлтэй байдаг бол эрэгтэй хантааз нь энгийн, хээ багатай байдаг. Хүйтэн цаг агаарт нэмэлт дулаан үүсгэх, баяр ёслолын үед гоёл болгон өмсдөг.

НООЛУУРАН ХУВЦАС


Ноолуур нь ямаанаас гаргаж авдаг, нарийн бүтэцтэй, байгалийн гаралтай ширхэгт юм. Ширхэгт нь байгалиас нано бүтэцтэй учраас дээд зэргийн зөөлөн, хөнгөн, дулаан, уян хатан, бөх бат, амьсгалдаг, агаар шүүдэг, галд тэсвэртэй, байгальд задардаг зэрэг хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй үзүүлэлтээрээ тансаг хэрэглээнд багтдаг. Байгалийн өнгө нь цагаан, саарал, бор байдаг бол чанарыг нь нарийн ширхэг болон диаметрээр (микрон), цагаан өнгө, уртаар нь шинждэг. Ноолуурыг будаж, ноолууран утас болгосны дараа цамц, ороолт, малгай, бээлий, оймс, цув, хантааз, дотуур хувцас, унтлагын хувцас, алчуур, хөнжил зэргийг хийнэ. Ноолууран хувцас нь нарийн ширхэгтэй тул арьсанд харшил үүсгэхгүй, зөөлөн, торгомсог мэдрэмж төрүүлдэг.

ДЭЭЛ

Дээл нь үндэсний онцлог хээг тусгасан торгон, даавуун эсвэл ноосон материалаар хийгддэг. Олон ястан угсаатны хувцасны хэв маяг өөрийн гэсэн онцлог загвартай. Дээлийг жилийн дөрвөн улиралд тохируулан оёж өмсдөг.



ХУВЦАС ЭДЛЭЛ



Хот: Улаанбаатар
 Дүүрэг: Сүхбаатар
 Хоршооны нэр: **"ЭЭЛТЭЙ БАЯЛАГ" ДУНДЫН ХОРШОО**
 Бүтээгдэхүүний нэр: **НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН**
 /цамц, өмд, юбка, малгай, ороолт, хүзүүвч, ханцуйвч/
 Орц: 100% Ямааны ноолуур /шаргал, бор/
 Хэмжээ: Чөлөөт, S, M, L, XL



ЭЭЛТЭЙ БАЯЛАГ

Хот: Улаанбаатар
Дүүрэг: Сүхбаатар
Хоршооны нэр: "ЭЭЛТЭЙ БАЯЛАГ" ДУНДЫН ХОРШОО
Бүтээгдэхүүний нэр: **НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН**
/хүүхдийн бойтог, малгай, майк, оймс, түлхүүрийн оосор/
Орц: 100% Ямааны ноолуур
Хэмжээ: 0-24 сар



ХУВЦАС ЭДЛЭЛ

ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠤᠯᠤᠰ





Аймаг:	Дархан-Уул
Сум:	Дархан
Хоршооны нэр:	ДАРХАН НООС
Бүтээгдэхүүний нэр:	ЭСГИЙ ШААХАЙ
Орц:	Хонины ноос
Хэмжээ:	35-42



Аймаг: Дархан-Уул
Сум: Дархан
Хоршооны нэр: **ДАРХАН НООС**
Бүтээгдэхүүний нэр: **ЭСГИЙ ЦҮНХ**
Орц: Хонины ноос



ХУВЦАС ЭДЛЭЛ



Аймаг: Сүхбаатар
 Сум: Баруун-Урт
 Хоршооны нэр: **БУМБАТ АЛТАН ШАГЛАА**
 Бүтээгдэхүүний нэр: **МОНГОЛ ДЭЭЛ, ЦАМЦ, БИЕЙН ТАМИРЫН ХОСЛОЛ, ХОРМОГЧ, БОМБЕР**
 Орц: Торго, даавуу
 Хэмжээ: Захиалгаар



ᠠᠶᠠᠨᠢ ᠪᠣᠯᠠᠨ ᠨᠣᠰᠣᠨ ᠬᠥᠨᠵᠢᠯ

Аймаг: Увс
Сум: Наранбулаг
Хоршооны нэр: **БОР МАЙХАН**
Бүтээгдэхүүний нэр: **АЯНЫ БОЛОН НООСОН ХӨНЖИЛ**
Орц: Хонины ноос, даавуу
Хэмжээ: 1 хүний, 2 хүний



സംഗ്രഹം • പാട്ട്



Аймаг:

 y_{BC}

Сум:

Малчин

Хоршооны нэр:

СҮРЛЭГ СҮРЭГ

Бүтээгдэхүүний нэр: **МОНГОЛ ГУТАЛ, ЦАГААН УЛТАЙ ГУТАЛ**

Орц:

Арьс, эсгий, даавуу

ХЭМЖЭЭ:

Захиалгаар



БУСАД

ЖАМЦ ДАВС

Эртний нууруудын булан тохойд үүсэж тунасан хуримтлалыг чулуун давс буюу жамц давс гэж нэрлэдэг. Жамц давс нь эрт галавын үед буюу одоогоос 400 сая жилийн өмнө манай гаригт үүссэн гэж эрдэмтэд тогтоожээ. Тус давсны найрлагад хүний биед зайлшгүй шаардлагатай кальци, кали, хүхэр, натри, төмөр, иод зэрэг эрдсүүд агуулагдсан байдаг. Жамц давс нь байгалийн эрдэст чанар, био идэвхт шинж, түүний найрлага дах амин хүчлүүдийн хамгийн чухлыг өөртөө шингээсэн өөрийн амин хүчлээр орлуулж болдог учир хүнсний хэрэглээнээс гадна ардын уламжлалт эмчилгээнд хэрэглэдэг.

ЛАА

Төрөл бүрийн ургамлаас бүтсэн цагаан лав бүхий лааг дээдсүүд л хэрэглэдэг байсан гэж түүхэнд тэмдэглэн үлдээжээ. Өнөө үед лааг цагаан лав, халимны тос, лаврын тос, зөгийн үүрээр бүтээдэг болсон байна. Гэр орон өрөө тасалгаагаа лаагаар чимэх нь уламжлал болон хэвшээд байна. Баярын ширээн дээр лаа тавихдаа ширээний бүтээлэг, амны алчуур зэрэг бусад чимэглэлтэй өнгийг нь хослуулах хэрэгтэй. Мөн жижигхэн навтгар хундагыг усаар дүүргээд олон өнгийн лаа хөвүүлэн тавибал алжаал тайлан нүд хужирлах увдистай аж.

ЦАЙ

Монголчуудын идээ ундааны нэг төрөл нь сүүтэй цай юм. Сүүтэй цайг чанахдаа ургамлыг нунтаглан буцалгаж хүрэн улаан өнгөтэй болсон хойно нь сүлдэг. Сүүтэй цайг сулийн гурил, арвайн гурилтай хольж хэрэглэх нь шим тэжээлээр баялаг, ходоод цэвэршүүлэх, шингэлт сайжруулах, цангаа тайлах зэрэг олон ач тустай.

БОРДОО

Бордоо нь химийн эсвэл байгалийн гаралтай ургамлын ургалтад шаардлагатай тэжээлүүдийн нэгдэл юм. Бордоо нь ургацыг нэмэгдүүлэхэд тэжээлийн үүрэг гүйцэтгэх, хөрсний ус барих чадвар ба агааржуулалтыг барих замаар хөрсний идэвхийг нэмэгдүүлдэг байна.

БУСАД



Аймаг:	Увс
Сум:	Улаангом
Хоршооны нэр:	ХАСУ ДЭВШИЛ
Бүтээгдэхүүний нэр:	ЖАМЦ ДАВС, ЦАЙНЫ ХУЖИР, ЖАМЦ ДАВСНЫ НҮД, ЖАМЦ ДАВСАН ТАВАГ
Орц:	Цагаан жамц давс
Хэмжээ:	760гр, 450гр, 200гр, 150гр, 110гр, 100гр



МОНГОЛ

Аймаг: Говьсүмбэр
Сум: Шивээговь
Хоршооны нэр: ЦАГЛАШГҮЙ ШИВЭЭ ЦАХИР
Бүтээгдэхүүний нэр: ЗАМБАЙН ГУРИЛ, СУЛИЙН ГУРИЛ, ЦУЛЬХИРЫН ГУРИЛ, ТЭЖЭЭХҮЙН УМДААН, БОРЖИГИН ГОЛОМТ ЦАЙ, ЧОНОН ХАРМАГ ЦАЙ, ИНГЭНИЙ СҮҮТЭЙ АЯНЫ ХИЙЦТЭЙ ЦАЙ
Орц: Арвайн гурил, олон төрлийн эмийн ургамал, ингэний сүү, агшаасан шар будаа, цайны хужир, шар тос, давс, нимбэг, мөсөн чихэр
Хэмжээ: 40ш, 20ш, 1 уут



БУСАД

МОНГОЛ



Аймаг:	Сэлэнгэ
Сум:	Шаамар
Хоршооны нэр:	СЭЛЭНГИЙН БЭЛЧИР
Бүтээгдэхүүний нэр:	ЛАА
Орц:	Зөгийн сархинаг, хаалт, хөвөн, будаг
Хэмжээ:	20гр



Био Ялмаг

Аймаг:	Хэнтий
Сум:	Хэрлэн
Хоршооны нэр:	ЮДЭГИЙН ХӨНДИЙ
Бүтээгдэхүүний нэр:	БИО ЯЛЗМАГ
Орц:	Ашигтай бактери, эрдэс бодисууд, витамин, хөрсний антибиотик
Хэмжээ:	1кг



Scan me!

www.namac.coop

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 18А-1, 13381

Утас: 11-458899, 453535

Цахим шуудан: info@namac.coop



Scan me!

Facebook: [AGRI-COOP/Namac](https://www.facebook.com/AGRI-COOP/Namac)